

# ЦАХИМ СЭТГҮҮЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, 2021 оны 9 сар №001



# МОССУ

МОНГОЛЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН  
ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО

## “ДЭЛХИЙН ЖИШИГ ХОРШООНЫ ХӨГЖЛИЙГ НУТАГШУУЛАХ НЬ»

Монголын хадгаламж, зээлийн хоршоодын  
анхдугаар цахим форумд зориулсан тусгай  
дугаар



### Гарчиг

Дэлхийн жишиг хоршооны хөгжлийг нутагшуулах нь .....	2
Цахим форумын илтгэгчид.....	3
Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбоо.....	4
Дэлхийн байгаль хамгаалах сан... ..	5
Дэлхийн, хадгаламж зээлийн хоршоодын холбоо .....	6
Азийн хадгаламж зээлийн хоршоодын холбоо .....	7
Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо.....	8
Монголын хадгаламж, зээлийн хоршоодын салбарын статистик .....	9-10
Мэдээллийн булан.....	11-12
Холбоо барих .....	13

### Онцлох үйл явдал

- Монголын хадгаламж, зээлийн хоршоодын форум анх удаа цахимаар 2021 оны 9 дүгээр сарын 9-ны өдөр зохион байгуулагдана.



# “Дэлхийн жишиг хоршооны хөгжлийг нутагшуулах нь”

Монголын хадгаламж, зээлийн хоршоодын  
анхдугаар цахим форум  
2021 оны 9 сарын 9 өдөр



МОНГОЛЫН  
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧЫН  
НЭГДСЭН ХОЛБОО



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC



МОНГОЛЫН ХОРШООЛЫН  
ҮНДЭСНИЙ НЭГДСЭН ХОЛБОО



## Форумын зорилго

Монголын хадгаламж, зээлийн хоршоодын өмнө тулгамдаж буй асуудлуудаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, салбарын хөгжлийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх.

Хөтөлбөр

13:00-13:30 Нээлт

13:30-13:50 Мэндчилгээ

13:50-14:10 Монголын хоршоодын өнөөгийн байдал

14:10-14:40 Хадгаламж зээлийн хоршоодын (ХЗХоршоо) салбарын хөгжил ба өнөөгийн байдал,  
тулгамдаж буй асуудал

14:40-15:10 ХЗХоршооны салбарын хууль эрх зүйн зохицуулалтын тухай болон цаашид хэрэгжүүлэх бодлогууд

15:10-15:25 Завсарлага

15:25-16:05 Орон нутгийн хоршоодоор дамжуулан байгаль экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах үйлсэд иргэдийг татан оруулах

16:05-17:05 Хэлэлцүүлэг

17:05-17:15 ФОРУМ-аас гаргасан санал уриалга

17:15 Хаалт - Фото

## Цахим форумын илтгэгчид



МХЗХҮХ-ны  
Тэргүүн  
Ц. Оюунцэцэг



МХҮНХ-ны  
Дэд тэргүүн  
Ц. Алтантуяа



СЗХ-ны ХЗХоршооны  
Газрын дарга  
Ц. Алтантуул



МБАНХ-ны  
ХЗХоршооны  
Хөгжил хариуцсан  
зөвлөх



ДБХС-ын  
Төслийн бизнесийн  
зөвлөх  
Э. Золбаяр



## Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны танилцуулга

Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо (МБАНХ) нь малчид болон орон нутгийн малчдын хамтын байгууллага (сум, аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо)-ын санал санаачлагаар байгуулагдсан гишүүддээ болон нийгэмд үйлчилдэг үндэсний хэмжээний төрийн бус байгууллага юм.

Монголын нүүдлийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах нь манай улсын бүх хүн амын тэн хагасыг ажлын байраар хангадаг, үндэсний үйлдвэрлэлийн түүхий эдийн бааз, үндэсний эдийн засгийн хоёрдахь том түшиг тулгуур, нийт газар нутгийн 70 гаруй хувийг эзэлдэг тал хээр нутгийн эко системийг хамгаалах үндсэн ач холбогдолтой юм.



**МОНГОЛЫН  
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН  
НЭГДСЭН ХОЛБОО**



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC

МБАНХ нь 2017 оноос «Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон Алт-Малын эрүүл мэндийн төсөл»-ийг хэрэгжүүлж эхлүүлснээр МХЗХҮХолбоотой хамтран бэлчээр ашиглагчдын хэсгийн гишүүн малчид, дундын сангийн гишүүддээ ХЗХоршоо үүсгэн байгуулах болон хамтарч ажиллахад туслалцаа үзүүлэн ажиллаж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар 9 аймгийн 44 сумдад ХЗХоршоо үүсгэн байгуулахад туслаж улмаар хөгжил дэвшилд нь арга зүйн туслалцаа үзүүлж ажилласны үр дүнд зорилтот ХЗХоршоодын нийт гишүүдийн тоо 7 770, нийт актив хөрөнгө 6.1 тэрбумд хүрсэн. ХЗХоршоодын гишүүд ХЗХоршоодыг чадавхжуулах дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагаануудыг явуулж байна. Үүнд:

- Санхүүгийн хэрэгцээгээрээ нэгдэж ХЗХоршоо байгуулан хоршин хөгжүүлэх
- Дундын сангаас ХЗХоршоонд шилжихэд сургалт, болон арга зүйн зөвлөгөө өгөх
- Байгуулагдсан ХЗХоршоонд дэмжлэг үзүүлэх
- Тогвортой хөгжиж зөв суурь бүтцийг бүрдүүлэн ажиллахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх



# Дэлхийн байгаль хамгаалах сан



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь Монгол улсын Засгийн газрын урилгаар анх 1992 онд байгуулагдсан бөгөөд дараагаар нь албан ёсоор Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн салбараар бүртгэгдсэн түүхтэй.

Тус хөтөлбөрийн газар нь Монголд үйл ажиллагаа явуулж буй байгаль хамгаалах хамгийн их баялаг туршлагатай байгууллагуудын нэг бөгөөд биологийн олон янз байдлаараа баялаг, дэлхийд хосгүй хоёр газар нутагт хамгааллын үйл ажиллагаа явуулдаг. Үүнд, баруун Монголын Алтай Соёны экобүс нутаг буюу “Цоохор ирвэсийн өлгий нутаг”, нутгийн зүүн хэсгийг багтаасан Амар мөрний экобүс нутаг юм.

Улаанбаатар хот дахь төв оффис, түүнчлэн Ховд аймгийн төв болон Хэнтий аймгийн Дадал суманд тус бүр салбартайгаар үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй мэргэжилтэн ажилтантай. Хөтөлбөрийн газар нь байгаль орчин, аялал жуулчлалын яам, шинжлэх ухааны байгууллага, үндэсний тэргүүлэх төрийн бус байгууллага, олон улсын төсөл, орон нутгийн төрийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдтэй нягт хамтран ажиллаж Монгол орныхоо байгаль, зэрлэг амьтадын хамгаалалд хувь нэмрээ оруулж байна.



Өөрийн хуримтлалаасаа бидэнд илгээж байгаль хамгаалалд зориулан хандив өгсөн танд баярлалаа

Зургийг зөвшөөрөлтэй нийтлэв.



Намайг Анар гэдэг. Ирвэстэй нутгийн ирээдүй төслийн ах эгч нартай танилцаж суманд маань хамгаалах ёстой цөөрч байгаа амьтад байгааг мэдэж авсан. Төслийн ах эгч нар маань миний энэ мөнгийг хүүхдүүдийг байгаль хамгаалах эрмэлзлэлтэй болгох ажилд зориулна гэж хүлээж байна.



МХЗХҮХолбоо нь 2018 оноос хамтран ажиллаж иргэдэд санхүүгийн мэдлэг олгох сургалт, хадгаламж зээлийн хоршоо байгуулах зөвлөгөө үйлчилгээ болон газар дээрх сургалтуудыг зохион байгуулж Увс, Баян-өлгий, Говь-Алтай, Ховд аймгийн 12 суманд шинээр ХЗХоршоод байгуулагдсан. Мөн байгуулагдсан хоршоодын гүйцэтгэх алба болон сонгуульт ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхжуулах тал дээр хамтран ажиллаж 2021 оны хагас жилийн байдлаар зорилтод сумдын хоршоодын нийт гишүүд 2 837, нийт актив хөрөнгө нь 2.4 тэрбум төгрөг болж өргөжиж 12 суманд орон нутгийн иргэдийн өмчлөл бүхий дундын санхүүгийн байгууллага амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр ХЗХоршоод гишүүддээ үйлчилгээ үзүүлэхээс гадна байгаль орчин, нийгэм орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна.



## Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (World Council of Credit Unions, WOCCU)



1970 онд ХЗХоршоодын олон улсын нэгдэлийг (CUNA) дэлхийн хадгаламж зээлийн холбоо болгон шинэчлэн байгуулсан (World Council of Credit Union, WOCCU).

Энэхүү холбооны зорилго нь дэлхий дахинаа ХЗХоршоодын хөдөлгөөний хөгжил, хамтын ашиг сонирхолыг нэмэгдүүлэхийн төлөө бодлого зохицуулалтыг бий болгох, дэмжин сайжруулах явдал юм.

Одоогийн байдлаар нийт 118 улс орон гишүүнчлэлтэй ба зорилгынхоо хүрээнд гишүүн улс орнуудад ХЗХоршоодын тухай хуулийн зөвлөмж зөвлөгөө, боловсролын туслалцаа, техник технологи, эрдэм шинжилгээ судалгааны ажилд дэмжлэг үзүүлж байна.

### Дэлхийн хадгаламж зээлийн хоршоо

2019 оны 12 сарын 31 өдрийн байдлаар

Үзүүлэлт	Дэлхийд	Хойд америкт	Европд	Азид	Африк
ХЗХ-ны тоо	86 055	5 825	3 574	33 634	39 666
Гишүүдийн тоо	291.4 сая	132.2 сая	9.2 сая	64.8 сая	37.8 сая
Нийт хөрөнгө	2,6 ихнаяд \$	1,9 ихнаяд \$	34,4 тэрбум \$	440,0 тэрбум \$	11,8 тэрбум \$

Эх үүсвэр : <https://www.woccu.org/>



## ASSOCIATION OF ASIAN CONFEDERATION OF CREDIT UNIONS

Dedicated Services to Asian Credit Unions Since 1971

### Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо

*(Association of Asian Confederation of Credit Unions, ACCU)*

Азийн бүс нутгийн ХЗХоршоодын хөгжил болон зохион байгуулалтыг дэмжих, судалгаа сургалт мэдээллээр хангах зорилгоор 1971 оны 4-р сард БНСУ-ын Сөүл хотод Солонгос, Хонконг, Филиппин, Тайланд, Япон зэрэг 5 орон нийлж байгуулсан. Энэ жил 50 жилийн ойгоо цахимаар тэмдэглэн өнгөрүүлсэн.

Зорилго нь азийн орнуудын ХЗХоршоодын хөгжил, хамтын ашиг сонирхолыг нэмэгдүүлэхийн төлөө бодлого зохицуулалтыг бий болгох, дэмжин сайжруулах бөгөөд жил бүр азийн ХЗХоршоодыг хамруулсан форумыг зохион байгуулдаг. Энэхүү форумд МХЗХУХолбооны гишүүн хоршоодын сонгуульт болон гүйцэтгэх албаны ажилтанууд оролцох нь нээлттэй байдаг.

Энэхүү холбоо нь Тайланд Улсын Банкок хотод байрладаг.

Өнөөгийн байдлаар азийн нийт 23 орны хоршоодын холбоод гишүүнчлэлтэй.





## МОНГОЛЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО (МХЗХҮХ)

Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо 2007 онд үүсгэн байгуулагдан улмаар 2012 онд “Үндэсний” гэсэн статустай болсон.

МХЗХҮХолбоо нь хоршоодын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад туслах, хоршоог хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор төрийн болон гадаад дотоодын төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж ХЗХоршоодын эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, боловсон хүчнийг сургах, мэргэшүүлэх чиглэлээр ажиллаж байна.



## МХЗХҮХолбооны үйл ажиллагаанаас

### ХОРШООДОД ЧИГЛЭСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Засаглалийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ  
Санхүүгийн зөвлөх үйлчилгээ  
Хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ  
Багц үйлчилгээ  
Зайнаас зөвлөх

### НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Спортын арга хэмжээ  
Туршлага солилцох гадаад болон дотоод аялал  
Уулзалт хүлээн авалт


### СУРГАЛТ

СЗХороотой хамтран явуулж буй сертификаттай сургалтууд  
Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагаа  
Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа  
Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа  
Нягтлан бодох бүртгэлийн онцлог  
Зээлийн хорооны үйл ажиллагаа  
Гүйцэтгэх захирал болон нягтлан бодогчийн ахисан шатны сургалт

Хоршоодын сонгуульт болон гүйцэтгэх албыг чадавхжуулах сургалтууд  
ХЗХоршоодын бизнес төлөвлөгөө хэрхэн боловсруулах вэ?  
ХЗХоршоодын санхүүгийн менежмент  
ХЗХоршоодын балансын бүтэц ба санхүүгийн төлөвлөлтийг эксел загвараар хэрхэн хийх вэ?  
ХЗХоршоодын архив, албан хэрэг хөтлөлт  
ХЗХоршоодын маркетинг бүтээгдэхүүн хөгжүүлэлт



## Монголын хадгаламж зээлийн хоршоодын салбарын статистик



## Хадгаламж зээлийн хоршоодын гишүүдийн мэдээлэл




Хуулийн этгээд  
183



Хувь хүн  
73,536



Эмэгтэй гишүүн  
37,330



- 20-100 гишүүнтэй
- 101-500 гишүүнтэй
- 501-1,000 гишүүнтэй
- 1,001-ээс дээш гишүүнтэй

## МХЗХҮХолбооны статистик /2021 оны 2-р улирлын байдлаар/



- Гишүүн хоршооны тоо – 177
- Гишүүдийн тоо – 62 767
- Гишүүн хоршоодын нийт хөрөнгө – 225,3 тэрбум төгрөг

# МЭДЭЭЛЛИЙН БУЛАН

## Мэдлэгт дусал нэмэр

### Хоршооны нийгмийн зорилгууд

#### БАЙНГЫН СУРГАЛТ

ХЗХоршоо нь гишүүд, удирдлага, олон нийтэд ХЗХоршооны олон улсын зарчмууд болон үнэт зүйлсийн талаархи сургалтыг идэвхтэй явуулна. Арвич хямгач байхад дэмжих, зээлийн зохистой хэрэглээ, гишүүдийн эрх үүргийн сургалт зэрэг гишүүдийн нийгэм эдийн засгийн онцлог шаардлагад нийцсэн сургалтуудыг тогтмол зохион байгуулна.



#### ХОРШООДЫН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХЗХоршоо нь хоршооллын зарчмын дагуу гишүүд болон бүс нутгийн эрх ашигт хувь нэмрээ оруулахын тулд өөрийн хүчин чадлын хүрээнд бусад ХЗХоршоо, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.




#### НИЙГМИЙН ЗОРИЛГО

ХЗХоршоо нь нийгмийн хөгжлийн төлөө тэмүүлнэ. Нийгмийн шударга ёс нь ХЗХоршооны алсын хараа байх төдийгүй гишүүд болон тэдний ажиллаж амьдарч буй нийгмийн сайн сайхны төлөө ажиллана. ХЗХоршооны нь гишүүн, гишүүн бус байхаас хамаарахгүй бүхий л хүмүүст ХЗХоршооны тухай ойлголтыг өгөх, гарах шийдвэр нь гишүүний оршин амьдрах илүү таатай өргөн цар хүрээтэй нийгмийг бий болгоно.



## ХЗХ болон Банк хоорондын харьцуулалт



### Гишүүдийнхээ нийгмийн байр суурийг нэмэгдүүлэх олон нийтийн үйл ажиллагаанууд /БНСУ-ын ХЗХоршоодын туршлагаас/

Зохион байгуулдаг арга хэмжээнүүд	Төрлөөр нь	Нийгмийн, халамжийн	Гадаад үйл ажиллагаа
Уулчдын уулзалт Уулын дугуйны цуглаан Хөлбөмбөг сонирхогчдын тоглолт Загасчлалын дугуйлан Фитнесс, Ёог, Аэробек Бүжгийн анги Дууны дугуйлан Гишүүдийн амьдралд тустай тусгай хөтөлбөр Нүүр будалт/Make up/ Хөнгөн атлетикийн тэмцээн Алхалтын тэмцээн Газрын теннисний клуб Марафон Гишүүний аялал Сайн дурын ажил Газар тариалангийн сургалт	Гэр бүлийн хоолны тэмцээн Төрсөн өдрийн баяр Гишүүдийг эмнэлэгт эргэх -цэцэг явуулах Гишүүдийн шагнал урамшуулалт баяр хүргэх Тэргүүний гишүүдийн үйл ажиллгаа Шинээр элссэн гишүүдийн мэндчилгээ Шинэ гишүүний сургалт Шинэ, үйл ажиллагаа дэлгүүрийн нээлтэнд баяр хүргэх Үл хөдлөх хөрөнгийн зуулчал, хууль эрх зүйн зөвөлгөө, Томоохон зээлдэгчдэл зөвлөх, дэмжих Өсвөр насныхны эдийн засгийн сургалт Хүүхдийн уран бичлэгийн анги	Аялалын үйл ажиллагаа Буяны үйл ажиллагаа Машин засварын ү/а Дэлгүүрүүдэд харилцан туслалцах Бизнест туслах Гэрийн эзэгтэй нарыг ажиллуулах Гишүүнчлэлийн ү/а Автобусны үйлчилгээ Заал, клубын түрээс Номын түрээс Хичээлийн давтлагын өрөө түрээс Хүүхдийн цэцэрлэг Зочдын өрөө Яармаг, зах нээх Үзвэр, кино клуб	Тэтгэлэгт оюутан шалгаруулах Хүүхдийн баярын арга хэмжээ Эцгээ эхээ ачласны сайшаал Хамгийн сайн сурагч шалгаруулах Хоцорогдолтой сурагчид туслах Будаа тараах Алс бөглүү нутгийн хүүхдүүдийг урих Аав ээжийн өдрийн арга хэмжээ Ганц бие хөгшидөд туслах Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг Байгаль орчин (цэвэрлэгээ)


## ХОЛБОО БАРИХ

facebook

Сургалтын групп/Facebook/




Гүйцэтгэх захирлуудын /групп/



Нүүр номын хуудас /Facebook/



Нягтлангуудын групп/Facebook/



Пэйж хуудас /Facebook/



Хаяг: БЗД 1-р хороо Энхтайвны өргөн чөлөө 18/А байр 405 тоот



Утас: 70001093



Харилцааны менежер утас: 8868 1093

Емэйл хаяг: moccu321093@gmail.com